



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 3-р сарын 20-26-
ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 3-р сарын 20-26-ны байдлаар

COVID-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийн хоёр дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Дэлхийн эдийн засаг 2020 онд агших төлөвтэй байгааг олон улсын санхүүгийн байгууллагууд болон шинжээчид анхааруулж байна¹. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв саарахад БНХАУ-ын эдийн засгийн өсөлт оны эхний улиралд огцом агших, COVID-19 вирусийн тархалт хүчтэй дэгдэж буй Евро бүс, АНУ-ын эдийн засаг 2020 оны II, III улиралд эрэлт болон нийлүүлэлтийн томоохон сөрөг шоконд өртөж, эдийн засаг агших төлөвтэй байгаа² нь голлон нөлөөлнө гэж шинжээчид үзэж байна. Гэхдээ эдийн засгийн нөхцөл байдал өдөр бүр хувьсан өөрчлөгдөж, тодорхой бус байдал өндөр байгаа тул дэлхийн эдийн засгийн өсөлт хэр гүнзгий унах вэ гэдэгт шинжээчид ялгаатай байр суурьтай хандаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, 2020 оны 3-р сарын байдлаар

	Төсөөлөл гаргагч байгууллагууд	2020 он				
		Төсөөлөл гаргасан огноо	Дэлхийн Э/З-ийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүсийн өсөлт
1	Goldman Sachs	3/23/2020	-1.0%	-	-	-1.7%
2	Barclays	3/20/2020	0.4%	1.3%	-0.6%	-2.4%
3	Bank of America	3/20/2020	0.3%	1.5%	-0.8%	-
4	Fitch	3/19/2020	1.3%	2.0%	1.0%	-0.4%
5	Morgan Stanley	3/18/2020	0.9%	5.0%	1.6%	-5.0%
6	Citi group	3/18/2020	1.4%	3.7%	1.4%	-
7	JP Morgan	3/13/2020	-1.1%	-	1.8%	-
8	China International Capital Corporation	3/24/2020	-	2.6%	-	-
9	Economic Intelligence Unit	3/18/2020	-	1.0%	-	-
10	Bloomberg	3/22/2020	-	1.4%	-	-
	Дундаж		0.3%	2.3%	0.7%	-2.4%

Эх сурвалж: Төсөөлөл гаргагч байгууллагуудын цахим хуудас

¹ ОУВС-аас дэлхийн эдийн засгийн өсөлт 2.5 хувиас доош орох тохиолдолд 'дэлхийн эдийн засгийн хямрал' бий боллоо гэж тодорхойлдог байна.

² Morgan Stanley-ийн эдийн засагчид АНУ-ын ДНБ II улиралд 30 хувиар буурна, ажилгүйдлийн түвшин дунджаар 12.8 хувь болж, хэрэглээ 31 хувиар буурах тооцоог хийжээ. "PMorgan-ийн шинжээчид АНУ-ын ДНБ-ийг II улиралд 14 хувиар агших, Goldman Sachs-ийн шинжээчид 24 хувиар агших тооцоо тус тус гаргаад байна.

- **Холбооны нөөцийн банкны тэргүүн асан Б.Бернанке 3-р сарын 25-ны өдөр CNBC телевизэд өгсөн ярилцлагадаа АНУ-ын эдийн засаг II улиралд огцом агших эрсдэлтэй ч, эргээд харьцангуй хурдан сэргэх боломжтойг илэрхийлсэн.** Үүний тулд ажлын байрыг хамгаалах ёстойг онцолжээ. Түүнчлэн, COVID-19-ийн тархалтыг хяналтад оруулах нь хамгийн чухал болохыг онцлоод, үүнийг хийхгүйгээр ямар ч төсөв, мөнгөний бодлого тус болохгүйг анхааруулав. Энэ удаа вирусийн нөлөө санхүүгийн зах зээл дээр мэдрэгдэж паник савлагаа үүсгэж байгаа ч, 1930-аад оны Их хямрал, 2008-09 оны дэлхийн санхүүгийн хямралаас ялгаатай учраас вирусийг хяналтад оруулсан тохиолдолд төсөв, мөнгөний бодлогоор даамжирсан уналтаас сэргийлж, эдийн засгийг хурдтай сэргээх боломжтойг дурджээ.
- ОУВС-ийн тэргүүн К.Георгиева 3-р сарын 23-ны өдрийн мэдэгдэлдээ COVID-19 вирусийн тархалт дэлхий нийтэд нэмэгдэхийн хэрээр дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, **дэлхий эдийн засагт 2008-09 оны санхүүгийн хямралаас ч том хямрал нүүрлэж болзошгүйг онцлов.** Дэлхийн эдийн засаг 2020 онд агших хэдий ч, 2021 оноос сэргэх боломжтой гэж хэлэв.

2008-09 оны санхүү, эдийн засгийн хямрал дэлхийн эдийн засгийн өсөлтөд -0.6 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн гэх тооцоо байдаг бөгөөд тухайн үед одоогийн нөхцөл байдлаас ялгаатай нь БНХАУ болон бусад эрчимтэй хөгжиж буй орнуудынх өссөн хэвээр байжээ. Харин өнөөгийн нөхцөлд дэлхий нийтээр эдийн засгийн төлөв хүнд байгаа бөгөөд хөрөнгө оруулагчид одоогоор 83 тэрбум ам.долларыг хөгжингүй орнуудаас татсан, 80 гаруй орон ОУВС-аас яаралтай дэмжлэг хүсээд байна³.

- COVID-19 вирусийн нөлөөгөөр **Европын** томоохон эдийн засгуудад аж үйлдвэрлэл, үйлчилгээ зогссонтой холбоотойгоор **менежерийн худалдан авалтын (PMI) индекс** 1998 оноос хойш түүхэн доод хэмжээнд хүрч унав. Тухайлбал, үйлчилгээний PMI индекс 2-р сард 52.6 байсан бол 3-р сарын 24-ны байдлаар 28.4 болж 46 хувиар, аж үйлдвэрийн PMI индекс 2-р сард 48.7 байсан бол, одоо 39.5 болж 19 хувиар тус тус буураад байна.
- Манай улсын экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлтийг нэгтгэн Хавсралт 2-д харуулав.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг** энэ оны 2-р сарын эцэст потенциал түвшин 60-70 хувь, 3-р сарын 6-ны байдлаар 70-80 хувь, 3-р сарын 17-ны байдлаар 80-85 хувиар ажиллаж байсан бол 3-р сарын 20-ны байдлаар **85 хувиас дээш түвшинд ажиллаж байна.** Аж үйлдвэрлэлийн

салбарын ажилчдын 80 гаруй хувь нь эргээд ажилдаа орсон⁴ бөгөөд ийнхүү аж үйлдвэрлэлийн салбар дахь ажиллах хүчин нэмэгдэж байгаа үед эдийн засгийн салбарууд алгуур сэргэх хүлээлттэй байна.

³ [IMF Managing Director Kristalina Georgieva's Statement Following a G20 Ministerial Call on the Coronavirus Emergency](#)

⁴ Хятадын Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас энэ оны 3-р сарын 19-ний өдөр хийсэн мэдэгдэл

- COVID-19 вирусийн тархалт буурч, гаднаас зөөвөрлөгдөн ирснээс бусад дотоодоос тохиолдол бараг илрээгүй тул **Хятад Улс** Вухан хотоос бусад **Хубэй муж дахь шилжилт хөдөлгөөний хорио цээрийн дэглэмээ 3-р сарын 25-ны өдрөөс эхлэн цуцаллаа**. Энэ нь нийт үйлдвэрлэлийн 44 хувийг эзэлдэг үйлчилгээний салбар болон жижиг боловсруулах үйлдвэрүүдийн ажиллах хүчний нийлүүлэлтэд эерэгээр нөлөөлнө гэж хүлээж байна.
- **Хятадын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл шинэчлэгдэж байна**
Хятадын Ардын Банк (ХАБ)-аас Хятадын эдийн засаг потенциал түвшиндээ хурдан эргэж очих боломжтой, эдийн засгийн сэргэлтийг мөчлөгийг ‘V’ хэлбэртэй байх төлөвтэй гэсэн мэдэгдлийг 3-р сарын 23-нд хийв. Хятадын олон улсын хөрөнгийн корпорацаас Хятадын эдийн засгийн өсөлт энэ онд 2.6 хувьтай гарах төсөөллийг 3-р сарын 24-ны өдөр зарлав. Харин Блүүмбергийн шинжээчид 3-р сарын 22-нд Хятадын 2020 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 1.4 хувь байна гэж өмнөх 7 хоногоос бууруулсан бол EIU байгууллага 3-р сарын 18-нд төсөөллийг 1.0 хувьд хүргэж бууруулаад байна (Хүснэгт 1). Блүүмбергийн шинжээчдийн төсөөлөл нь Хятад энэ оны I улиралд вирусийг хяналтдаа авах бол харин Америк болон Европын холбооны орнууд II улирлын эцэст хяналтдаа авч, улмаар оны эхний хагаст Хятадын гадаад эрэлт сул байж, оны сүүлийн хагаст сэргэнэ гэсэн таамаглалд суурилан хийгджээ. Хэрэв вирусийн тархалт төсөөллөөс удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд Хятадын эдийн засгийн төлөв одоогийн төсөөллөөс муудаж болзошгүй.
- Financial Times сэтгүүлээс тооцсон **Хятадын эдийн засгийн идэвхжлийн индекс нь эдийн засгийн идэвхжил**

алгуур сэргэж байгаа хэдий ч, хэвийн түвшинд хараахан хүрээгүйг илтгэж байна. Тухайлбал, тус индексийн тооцоогоор Хятадын эдийн засгийн идэвхжил 2-р сард хамгийн доод түвшинд хүртэл буурсан бол, түүнээс алгуур хойш сэргэж 3-р сарын 23-ны байдлаар оны эхэн үеийн эдийн засгийн гүйцэтгэлийн 60 гаруй хувьтай тэнцэх түвшинд байна. Индексийн бүлгүүдээр задалж харвал, нүүрсний эрчим хүчний хэрэглээ оны эхэнтэй харьцуулахад 3-р сарын 23-ны байдлаар 71 хувь, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 52 хувь, ачаа тээвэрлэлт 70 хувь, авто замын түгжрэл 90 хувь, кино үзвэрийн борлуулалт 0 хувьтай байна.

- Шинээр зарлагдсан статистик мэдээллээр Хятадын дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалт 2020 оны эхний 2 сард 30 хувиар буурчээ.
- Хятадад вирус хяналтад орж, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаанд шилжиж байгаатай холбоотойгоор **гангийн үйлдвэрлэл сэргэж, үнэ өсч, нүүрсний хаагдсан байсан уурхайнууд нээгдэж эхэлж байна.** 3-р сарын 20-ны байдлаар гангийн нөөц буурч, бүтээгдэхүүний үнэ сэргэж эхэлсэн байна. Тэгвэл 3-р сарын 22-ны өдрийн байдлаар Хятадын нүүрсний хамгийн том нөөц газар болох Өвөр Монголд нүүрсний үйлдвэрлэл 88%-д хүрч, 280 уурхайн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх болсныг SXCoal мэдээлэв. Түүнчлэн 3-р сарын эцэс гэхэд стандарт хангасан бүх уурхайн үйл ажиллагааг эхлүүлнэ гэж мэдээлжээ.
- **Хятадын төсвийн бодлого**
Хубэй мужийн жижиг бизнесүүдийн НӨАТ-ыг тэглэж, бусад мужуудын жижиг бизнесүүдэд 3-р сараас 5-р сарыг дуустал НӨАТ-ыг 3 хувиас 1 хувь хүргэн бууруулсан. Орон нутгийн засгийн газрын тусгай зориулалттай бондын хэмжээ оны эхний 2 сард өмнөх

оны мөн үеэс 2 дахин нэмэгдэж, 904 тэрбум юаньд хүрчээ. Энэ нь 2020 онд төсөвлөгдсөн нийт дүнгийн 70 хувьтай дүйцэх хэмжээ юм. Сангийн яамнаас 3-р сарын 21-ний өдөр тусгай зориулалттай бондын эх үүсвэр нь бүхэлдээ дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулагдана гэж мэдэгдлээ⁵.

■ **Хятадын мөнгөний бодлого**

ХАБ 3-р сард банкуудын Заавал байлгах нөөцийн хэмжээг үе шаттайгаар бууруулан 550 тэрбум юанийг зах зээлд чөлөөлсөн бол нэмэлтээр 64 тэрбум юанийн санхүүжилт болон дунд хугацааны зээлийн шугамаар 100 тэрбум юанийн санхүүжилтийг санхүүгийн

захад нийлүүлж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжлээ. ХАБ-аас банкны секторт хөрвөх чадварыг нэмэгдүүлэх санхүүжилтийг хийж байгаа ба 2-р сарын эхний хагаст 3 их наяд юанийг олгосон⁶. 2020 оны 2-р сард ХАБ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд 800 тэрбум юанийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэнээс одоогийн байдлаар 500 тэрбум юанийн дэмжлэг олгосон гэж Блүүмбергийн шинжээчид тооцож байна. ХАБ энэ онд бодлогын хүүг дахин 0.4 нэгж хувиар бууруулах, Заавал байлгах нөөцийн хувийг 1.5-2.0 нэгж хувиар бууруулах хүлээлт хэвээр байна.

3 ГЛОБАЛ ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД, БОДЛОГЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Улс орнууд COVID-19 вирусийн эдийн засагт үзүүлэх үр дагаврыг бууруулах төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээг шуурхай авсаар байна.

Мөнгөний бодлого

- Өнгөрсөн 7 хоногт дэлхийн 40 орчим Төв банк хүүгээ бууруулах шийдвэр гаргав.
- Европын Төв банк COVID-19-тэй тэмцэх бодлогын хүрээнд нэмэлт 750 тэрбум еврогийн үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг 3-р сарын 18-ны өдөр гаргаснаар энэ онд худалдан авах бондын дүн 1.1 их наяд еврод хүрлээ.
- Английн Төв банк 3-р сарын 12-ны өдөр бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар бууруулсан бол 3-р сарын 20-ны өдөр дахин 0.15 нэгж хувиар бууруулж, бодлогын хүүний түүхэн доод түвшин буюу 0.1 хувьд хүргэлээ. Мөн үнэт цаас худалдаж авах хөтөлбөрийн дүнг 200 тэрбум фунт стерлингээр нэмнээр энэ

онд нийт 645 тэрбум фунт (ДНБ-ий 30 орчим хувь) стерлингийн үнэт цаас худалдаж авахаар болов.

- Японы Төв банк 3-р сарын 19-ны өдөр хүлээлтийг намжаах зорилгоор 1 их наяд иен буюу 9.2 тэрбум ам.доллараар Засгийн газрын бонд худалдан авахаар шийдвэрлэв.
- АНУ-ын ХНБ-аас зах зээлд хөрвөх чадварын эрсдэл болон зээлийн тасалдал үүсэхээс сэргийлэх зорилгоор зээлийн тусгай сан байгуулж, 3-р сарын 20-ноос эхлэн арилжааны банк болон яаралтай бэлэн мөнгө шаардлагатай санхүүгийн байгууллагад хөнгөлөлттэй зээл олгож эхэллээ.

Төсвийн бодлого

- **АНУ-ын Сенат** 2020 оны 3-р сарын 25-ны өдөр COVID-19-ийн тархалтаас үүдэлтэй эдийн засгийн хохирлыг бууруулах зорилготой **2 их наяд**

⁵ 2019 оны байдлаар тусгай зориулалттай бонд олголтын 26 хувь нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бөгөөд 2019 оны 6-р сараас Үндэсний их хурлаас тус бондын орлогыг

дэд бүтцийн төслүүдэд зарцуулахаар шийдсэн байна.

⁶ ОУВС: [Policy Tracker](#)

ам.долларын дүнтэй (ДНБ-ий 10 хувьтай тэнцэх) эдийн засгийн багц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг гаргав⁷. Үүнд эдийн засгийн эргэлтийг зогсоохгүйн тулд бага, дунд орлоготой иргэн бүрт 1200 ам.долларын чек, хүүхэд бүрт 500 ам.долларын чек олгох, жижиг, дунд бизнесийг дэмжихэд 500 тэрбум ам.долларын зээл, тусламжийн сан үүсгэх, ажилгүйдлийн тэтгэмжийг 4 сараар сунгаж, нэмэлт 150 тэрбум ам.долларын сан байгуулах, эмнэлэг, эрүүл мэндийн хангамжид 150 тэрбум ам.доллар зарцуулах зэрэг багтжээ. Энэхүү эерэг мэдээний нөлөөгөөр ихээр унаад байсан DOW Jones индекс болон S&P500 индексүүд 3-р сарын 24-нөөс эргэн сэргээд байгаа бол ам.долларын ханш суларч эхэлж байна.

- БНСУ-ын Засгийн газар 3-р сарын 18-нд эдийн засгаа дэмжих зорилгоор 11.7 их наяд вон буюу 9.4 тэрбум ам.долларын тусгай төсөв батлав. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгч болон хувиараа бизнес эрхэлдэг иргэддээ зориулж нийт 12 их наяд вонын зээлийг 1.5 хувийн хүүтэй олгохоос гадна, 5.5 их наяд вонын зээлд батлан даалт гаргах юм байна.
- Австралийн Засгийн газар хямралаас сэргийлж, ажлын байруудыг хадгалах зорилгоор өнгөрсөн Даваа гарагт 80 тэрбум австрали долларын төсөв баталсан бол 3-р сарын 22-ны өдөр нэмэлт 66 тэрбум австрали долларын төсвийг баталлаа.
- Бусад улс орнуудад авч хэрэгжүүлж буй төсвийн, мөнгөний болон бусад бодлогын арга хэмжээний дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав.

4 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, (2) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх, (3) бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргасан.

Харин 3-р сарын 20-ны өдөр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авав.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 20¹ дүгээр зүйлийн 1-д Монголбанк банкны системийн эцсийн зээлдүүлэгчийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нь түр хугацааны хүндрэл үүссэн, өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэлээс гарч, зээлийг хугацаанд нь эргэн төлөх боломжтой, төлбөрийн чадвартай банканд тодорхой нөхцөлийн дагуу барьцаатай зээл олгож болно хэмээн заасан байдаг.

Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа зогссон, Төв банкны үнэт цаас цөөн банкинд төвлөрсөн байгаа өнөөгийн нөхцөлд COVID-19 вирусийн хурдацтай тархалтаас үүдэн дотоод эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс

⁷ CNN: [What's in the \\$2 trillion coronavirus stimulus bill](#)

сэргийлэх, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк барьцаат зээлийн журамд 2020 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл түр хугацааны өөрчлөлт орууллаа. Үүнд:

- Барьцаат зээлийн хугацааг 90 хүртэл хоног байсныг 180 хүртэл хоногийн хугацаатай болгож хугацааг уртасгав.
- Барьцаат зээлийн хүүг 16 хувь байсныг 11 хувь болгон бууруулав.
- Барьцаа хөрөнгийн жагсаалтыг тэлж, санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэв (Хүснэгт 2).

Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

Эдгээр мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй COVID-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

Хүснэгт 2. Барьцаат зээлийн журамд орсон өөрчлөлт

	Өмнө	Өөрчлөлт
Урьдач нөхцөл	1. Төлбөрийн чадвартай ч түр зуурын хүндрэл үүссэн, 2. Зээлээ эргүүлэн төлөх боломжтой, 3. Бусад арга хэмжээг авсан	1. Төлбөрийн чадвартай ч түр зуурын хүндрэл үүссэн, 2. Зээлээ эргүүлэн төлөх боломжтой, 3. Бусад арга хэмжээг авсан
Хугацаа	90 хоног (+ 90 хоног)	180 хоног (+ 180 хоног)
Хүү	Репо санхүүжилтийн хүү + 5 нэгж хувь = 16 хувь	Репо санхүүжилтийн хүү = 11 хувь
Барьцаа	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, МУ-ын Хөгжлийн банкны үнэт цаас, Хэвийн зээл*	*+Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс Монгол ХХК-аас гаргасан Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-аас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд
Бүрдүүлэх баримт	1. Албан бичиг, 2. Барьцаалах актив, 3. Мөнгөн хөрөнгийн урсгалын таамаглал	1. Албан бичиг, 2. Барьцаалах актив, 3. Мөнгөн хөрөнгийн урсгалын таамаглал

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 3-р сарын 27-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар эдийн засгийн хүндрэлийг даван туулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх болсныг зарлав. Үүнд:

- 4-р сарын 1-нээс 10-р сарын 1-ны өдөр хүртэл ААН-үүдийн НДШ-ийг тэглэх;
- 4-р сарын 1-ээс 10-р сарын 1-ны өдөр хүртэл цалин хөлснөөс орлогын албан татвар авахгүй;

- 4-р сарын 1-нээс аравдугаар сарын 1-ны өдөр хүртэл 1.5 тэрбумаас доош орлоготой аж ахуй нэгжүүдээс татвар авахгүй;
- Ажлын байрыг хадгалж буй хувийн аж ахуй нэгжүүдэд 3 сарын хугацаанд сар бүр нэг ажилтанд 200 мянган төгрөг байхаар татаас олгох;
- Дотоодын компаниудад ноолуур бэлтгэхэд зориулж, 300 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3 хувийн хүүтэй олгоно. Энэ нь ноолуурын үнийг

бууруулахгүй байх, малчдын орлогыг дэмжинэ гэж үзсэн байна.

- 3 сарын хугацаанд хүүхдийн мөнгийг 10 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 30 мянган төгрөг болгох;


- 4-р сарын 15-наас шатахууны үнийг литр тутамд тодорхой хэмжээнд бууруулах.

5 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ: 2020 ОНЫ 2-Р САРЫН БАЙДЛААР


Монгол Улсын гадаад худалдааны эргэлт буурч, тэнцэл алдагдалтай гарлаа. Оны эхнээс 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 533 сая ам.доллар (23%)-аар буурч 1,818 сая ам.доллар болов. Үүнд экспорт 424 сая ам.доллар (32%)-аар, импорт 109 сая ам.доллар (11%)-аар тус тус буусан нь нөлөөлөв. Зөвхөн 3 дугаар сарын эхний 15 хоногийн байдлаар экспорт 101.4 сая ам.доллар (42%), импорт 21.6 сая

ам.доллар (11%)-аар буурсан байна. Өнгөрсөн хугацаанд үнийн уналт болон Засгийн газраас хэрэгжүүлж буй боомтын хязгаарлалтаас хамаарч экспортын орлого багассан нь гадаад худалдааны тэнцэл 20 сая ам.доллар (-315.2 сая ам.доллар)-ын алдагдалтай гарахад нөлөөлөв. Гадаад валютын орох урсгал 2020 оны 3 дугаар сарын 23-ны байдлаар 22% (-484.8 сая ам.доллар)-иар, гарах урсгал 6% (-111.6 сая ам.доллар)-аар тус тус буураад байна.

Зураг 1. Экспорт, импорт болон худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Зураг 2. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Монголбанк


Дэлхийн санхүүгийн зах зээлд коронавирусээс үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүд сүүлийн 1 сарын хугацаанд 30%-иар уналаа. Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж (sell off) илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөд эх үүсвэрээ

байршуулж эхэлснээр **Монгол Улсын Засгийн газар болон компаниудын бондуудын үнэ унаж**, өгөөж 2020 оны 3 дугаар сараас эхлэн огцом өслөө. Хэрэв дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал даамжирвал Монгол Улсын дахин санхүүжилтийн өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.


Эдийн засаг, бизнесийн идэвхжил саарсан хэдий ч, нийлүүлэлтээс шалтгаалсан инфляц бага зэрэг өсжээ. Жилийн инфляц 2 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.4%, Улаанбаатар хотын хэмжээнд 6.9% буюу өмнөх сартай харьцуулахад 0.9 нэгж

хувиар өссөн дүнтэй байна. Эдийн засгийн идэвхжил, ерөнхий төлөв саарах хандлагатай байгаа хэдий ч, иргэд, ААН-үүд нийлүүлэлтийн хомсдол үүсэх эрсдэлээс сэргийлж худалдан авалтаа нэмэгдүүлсэн нь богино хугацаанд инфляц бага зэрэг өсөхөд нөлөөлөв.

Зураг 3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, өсөлт, сараар



Зураг 4. МУЗГ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн боловч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8%-иар буурсан байна. 2020 оны 2 дугаар сарын төсвийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн нийт орлого 1369.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Татварын орлогын дэлгэрэнгүй задаргааг авч үзэхэд 2020 оны 2 дугаар сард нийт 598.9 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдсэний 36% (215.5 тэрбум төгрөг) нь ААНОАТ, 12% (74.3 тэрбум төгрөг) нь ХХОАТ, 26% (155.0


тэрбум төгрөг) нь НДШ байгаа бол ердөө 1 орчим хувь (3.7 тэрбум төгрөг) нь НӨАТ-ын орлого байна. НӨАТ-ын орлого өмнөх оны мөн үеэс 97.6% буюу 147.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь бизнесийн идэвхжил буурч байгааг илтгэж байна.

Харин төсвийн нийт зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.2%-аар өссөн буюу урсгал зардал 14.6% (168.5 тэрбум төгрөг), хөрөнгийн зардал 203.3% (115 тэрбум төгрөг)-аар тус тус өсжээ.

Хүснэгт 3. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, эхний 2 сар

	● Төсөв	● Гүйцэтгэл	● Хувь-1	● Зөрүү
Татварын орлого	1,186,526.8	1,255,245.0	105.8%	68,718.2
Татварын бус орлого	148,508.2	114,043.0	76.8%	-34,465.2
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,335,035.0	1,369,288.0	102.6%	34,253.0

Зураг 5. Татварын орлогын задаргаа



Эх сурвалж: Сангийн яам



ХАВСРАЛТ

Хавсралт 1. Улс орнуудын авч буй бодлогын арга хэмжээ (тархалтын түвшнээр)

АРГА ХЭМЖЭЭ	IV түвшин- (Европын орнууд болон АНУ)		III түвшин- (БНХАУ, Япон, Солонгос)		II түвшин- (Малайз, Канад, Сингапур, Тайланд, Индонез, Хонг Конг гэх мэт)		I түвшин- (Казахстан, Камбож, Афганистан, Узбекистан, Кени, Гана)			
	Одоо эрчимтэй тархаж буй		Эрчимтэй тархалтыг намжааж, хязгаарласан улс орнууд		Тархалтыг намжааж, сэргийлж байгаа улс орнууд		Шинээр тохиолдол нэмэгдсэн улс орнууд			
Төсвийн бодлого	ТБ1: Төсөв тодотгох	+	Ихэнх улсууд эдийн засгийг дэмжих, гамшгаас сэргийлэхэд их хэмжээний санхүүжилт гаргаж байна. Тухайлбал: - ЕХ: \$40 тэрбум - Итали улс: багадаа \$27 тэрбум - Испани улс: \$216 тэрбум - Франц улс: \$49 тэрбум + \$324 тэрбум /зээлийн батлан даалт/ - Герман улс: \$385 тэрбум	+	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, ЖДҮ-ийг дэмжихэд зарцуулна. БНХАУ: 173 тэрбум ам.долларыг эдийн засгаа сэргээхэд зарцуулахаар болов. Япон: 4 тэрбум ам.долларыг вирусийн эдийн засагт учруулсан хохирлыг барагдуулахад зарцуулна гэлээ. Ялангуяа ЖДҮ-д зарцуулна. БНСУ: 9.8 тэрбум ам.долларыг тус вирусгүй холбоотойгоор бий болох эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зарцуулна.	+	Ихээр хохирол амсаж буй салбаруудыг дэмжих хөтөлбөр, багц гарган боловсруулсан. Филиппин: \$518.7 сая багц баталсан. - Covid-19 тархалтыг намжаахын тулд \$59.3 сая - Аялал жуучлалын салбарыг дэмжих төрөл бүрийн хөтөлбөр, төсөлд \$267.9 сая - Өртөж буй байгууллагууд болон ажилчдад цалингийн татаас, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд \$38.3 сая - Ажилгүйдлийн тэтгэмжид \$23 сая - Түр хугацаанд ажлаа алдсан ажлын ур чадварыг сайжруулах чиглэсэн сургалт, семинарт \$57.4 сая - Жижиг фермерүүд болон загасчдыг дэмжих тэг хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн нийт санхүүжилт \$38.9 сая - ЖДҮ эрхлэгчдэд олгох тусгай зээлийн санхүүжилтийн хэмжээ \$19.1 сая			
	ТБ2: Хөнгөлөлттэй зээл олгох	+	ЖДҮ нарт тэр дундаа хохирол амссан компаниудад олгох. - Итали улс: \$16 тэрбум ЖДҮ зээл, - Герман улс: Бүх ЖДҮ нарт хөнгөлөлттэй зээл олгох боломжтойг мэдэгдсэн.	+	БНХАУ:Өртсөн бизнесүүдийн зээлийн хүүг бууруулах, итгэлийн зээл олгох, зээл олголтыг дэмжих, Япон: y/a нь доголдсон бизнесүүдэд зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэв. БНСУ: ЖДҮ-ийн зээлийн нөхцөлийг хялбаршуулсан.					
	ТБ3: Түрээс зогсоох	+	Европын ихэнх орнууд							
	ТБ4: Татаас, тэтгэмж олгох	+	Сул зогсолтод орж буй ажилчид, асаргаа хийж буй иргэдэд тэтгэмж олгох, ЖДҮ хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой. - Итали улс: \$11 тэрбум - Испани улс: \$648 сая - Франц улс: \$11 тэрбум - Герман: Хүнд байдалд орсон томоохон компаниудын хувьцааг худалдан авах.			+	Сул зогсолт хийж буй ажилчдад тэтгэмж олгох			



	ТБ5: Зээлийн батлан даалт гаргах	+	Их хэмжээний бизнесийн зээлд батлан даалтыг ЗГ-аас гаргах. - Испани улс: \$108 тэрбум зээл - Итали улс: \$324 тэрбум зээл					
	ТБ6: НДШ төлөлт хойшлуулах	+	Зарим төрлийн НДШ төлөлтийг түр хугацаанд хойшлуулах					
	ТБ7: Татвар төлөлт хойшлуулах	+	Ихэнх орнууд хойшлуулж байна. - Итали улс: \$35 тэрбум	+	БНХАУ: Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн хугацааг хамгийн ихдээ 5 жил байсныг 8жил болгон уртасгав.	+	1-6 сараар хойшлуулсан Филиппин: Орлогын албан татвар төлөлтийг 1 сараар хойшлуулсан. Ингэснээр \$2.8 тэрбум төсвийн орлого тасалдах юм.	
	ТБ8: Татварын хөнгөлөлт	+	Зарим орнууд хөнгөлөлт үзүүлж байна. - Итали улс: \$35 тэрбум	+	БНХАУ: Тархалтын эсрэг ү/а-ны тээвэр, материал ханган нийлүүлж буй ААН-н НӨАТ чөлөөлсөн, Хөнгөлөлттэй зээлийн бодлого баримталж буй Хубей мужийн жижиг бизнесүүдийн НӨАТ-ыг тэглэж, бусад мужуудын жижиг бизнесүүдэд 3-р сараас 5-р сарыг дуустал НӨАТ-ын хувийг бууруулсан.	+	Хохирол их амсаж буй салбарыг татварыг хөнгөлсөн, Цахилгааны зардлыг нь хөнгөлөх + Казакстан: -Ү/а-аа зогсоож буй байгууллагууд 1 жилийн эд хөрөнгийн татвараас, 1 улирлын зээлийн хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөнө. -ХАА-н бүтээгдэхүүн импортлогчид НӨАТ-аас чөлөөлөгдөнө.	
Мөнгөний бодлого	МБ1: Цахим төлбөр тооцоог дэмжих (Монголбанк хэрэгжүүлсэн)	+	Цахим банкны лимитийг нэмэгдүүлэх	+	Интернэт банкны хүчин чадал нэмэгдүүлэх Цахим банкны лимит нэмэгдүүлэх			
	МБ2: Бодлогын хүү бууруулах (Монголбанк хэрэгжүүлсэн)	+	АНУ: Зээлийн хүүг 0 түвшний орчимд байлгах.	+	БНСУ: түүхэн доод түвшинд (0.75) хүргэв БНХАУ: Зээлийн жишиг хүүгээ бууруулсан.	+	Ихэнх төв банкууд бууруулсан Филиппин: - 2 сард бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр бууруулан 3.75 хувьд хүргэсэн - 3 сарын 19-нд бодлогын хүүгээ дахин 50 суурь нэгжээр бууруулсан.	
	МБ3: Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг зөөлрүүлэх (Монголбанк хэрэгжүүлсэн)			+	БНХАУ			
	МБ4: ЗГ-ын үнэт цаас худалдан авах (ЗГҮЦ гарсан тохиолдолд боломжтой)			+	Япон: 12 их наяд иений үнэт цаас худалдан авахаа зарлав	+	Индонез: 2 тэрбум ам.долларын үнэт цаас худалдан авсан. Филиппин: ЗГ-ийн 6 сарын хугацаатай \$6 тэрбум үнэт цаасыг худалдан авсан.	
	МБ5: Хөнгөлөлттэй зээл	+	- Герман: Бүх компаниудад зээл олгох боломжтой талаар мэдэгдсэн.					



	олгох (Монголбанк барьцаат зээлийн хугацааг нэмэгдүүлсэн)	- Европын холбоо: барьцаа хөрөнгийн үнэлгээг зөөлрүүлэх байдлаар зээлийг дэмжих						
	МБ6: Зээл төлөлт хойшлуулах (Монголбанк хэрэгжүүлсэн)	+ Ипотек, хэрэглээний болон ЖДҮ зээл	+ БНХАУ: -Худалдаа, зочид буудал, хүнс, тээвэр, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн зээлийн хугацааг сунгах, -Орлогын эх үүсвэрээ алдсан иргэдийн зээлийн нөхцөлийг уян хатан болгох					
	МБ7: Овернайтын өөрчлөлт (Монголбанк хүүг бууруулсан)	+ Овернайтын хугацааг сунгах, хүүг бууруулах						
	МБ8: Уламжлалт бус бодлого	+ Европын төв банкнаас хувийн болон улсын байгууллагын үнэт цаасыг худалдан авах зорилго бүхий \$810 тэрбумын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ (Quantitative Easing).						
Эдийн засгийн бус арга хэмжээ	Тархалт өндөртэй улсаас зорчигч хүлээж авахаа зогсоох	+ Европын холбооны орнууд 1 сарын хугацаанд гадны иргэдийг хүлээн авахгүй АНУ: Европ, Ази нислэгүүдээ зогсоох	+		+		+	
	Сургуулийн ү/а-г зогсоох	+ Бүгд	+		+		+	
	Олон нийтийн ү/а-г зогсоох	+ Европын ихэнх орнууд	+		+		+	
	Хилийн боомтуудыг түр хаах	+ Хэсэгчилсэн	+		+	Хэсэгчлэн	+	Хэсэгчлэн
	Үйлчилгээний газруудыг хаах	+ Европын ихэнх орнууд	+		+		+	Казакстан: Дэлгүүр, кино театр, спортын газрууд Намиб: Музей, номын сан, галерейнүүдийг хаасан
	Виз олголт зогсоох	+ АНУ: Зарим орнуудад виз олголтыг хойшлуулсан				+		+
	Гэрээр ажиллахыг дэмжих	+ Европын ихэнх орнууд	+		+	Төрийн албан хаагчдыг гэрээр ажиллуулах	+	
	Ажлын цагийг богиносгох	+ Цаг богиносгосон компаниудад татаас олгох	+					
Вирус дэгдэлтийн бэлэн байдал хангах	+ ЕХ-ны орнууд эмнэлгийн ажилчдыг эргүүлэн татах, шинээр сургах	+	Covid-19-д зориулсан эмнэлгүүд	+			+	Covid-19 оношлуур



		ажиллагааг эрчимтэй хийж байна. - Итали улс: \$3.8 тэрбум - АНУ: \$8.3 тэрбумыг вакцин гарган авах болон ЭМ салбарт зарцуулах					Боомтууд дээр халуун хэмжигч	
Экспортын хориг			+	Амны хаалт, гар ариутгагч, халуун хэмжигч	+	Амны хаалт, гар ариутгагч	+	Казакстан: амны хаалт
Хог хоорондын хөдөлгөөнийг зогсоох	+	Европын зарим орнууд	+		+		+	Казакстан: Nur-Sultan, Almaty хотоос орох гарах хөдөлгөөнийг зогсоосон.
Хөл хорио тогтоох	+	- ЕХ орнууд: Дэлгүүр, эмийн сан явахаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй байх. - АНУ: Зарим мужид хорио тогтоосон.	+	БНСУ: дэгдэлт өндөртэй газруудын иргэдийг GP ашиглан хөл хорио тогтоов.	+			
Зөвлөмж зөрчсөн тохиолдолд торгууль оноох	+		+	Аяллын түүх худал мэдүүлэх, санаатайгаар бусад халдаасан тохиолдолд	+			
Бусад			+	БНХАУ, БНСУ: Мөнгөн дэвсгэртүүдийг ариутгасан БНХАУ: Маскны үйлдвэрлэл потенциал хэмжээнээсээ 450%-аар давсан.	+	Сингапур: COVID-19 эмчлүүлж буй гадаад иргэдээс төлбөр авах		



Хавсралт 2. Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

	Бодит гүйцэтгэл						2020 оны төсөөлөл				
	Үнэ 2020/03/24	Өөрчлөлт					Товч тайлбар	МБХ-д танилцуулсан	Шинэчлэгдсэн	Шинэчлэгдсэн огноо	Эх сурвалж
		өдрийн	7 хоног	сарын	оны эхнээс	жилийн					
Зэс	4811	0.70%	2.5%	-14.4%	-21.4%	-23.5%	COVID-19 вирусийн нөлөөгөөр зэсийн эрэлт улам саарахаар байна. Зах зээлд 800,000 тонн нийлүүлэлтийн илүүдэл үүсч болзошгүй байгаа нь 2001 оноос хойших хамгийн их илүүдэл юм.	5911	5863	III.25	Bloomberg
									5400	III.18	Roubini
									5989	III.23	BREE
Коксжих нүүрс	160	-	-	-	-	-	COVID-19 вирусийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөвтэй. Хятадын голлох цахилгаан станцуудын нөөц 31 өдөр хүрч нэмэгдсэн. Австралийн нийлүүлэлт тогтвортой байна.	152	160	III.25	Bloomberg
									160	III.23	BREE
Нүүрс /Хил/ 2020 оны 2-р сар	-	-	-	-14%	-7.2%	-16%	Нүүрсний экспорт 2-р сарын 11-с 3-р сарын 22-г хүртэл түр зогссон. Энэ сарын 23-аас гарч эхлээд байна.	67	-	-	-
Төмрийн хүдэр	80	-0.3%	-6.4%	-5.5%	-13.8%	-1.9%	Хятадын аж үйлдвэрлэлийн эрэлт буурахаар байна. Нийлүүлэлт талаас илүү хувийг бүрдүүлдэг Австралийн нийлүүлэлт тогтвортой байгаа нь үнэ буурахад нөлөөлж байна.	72	79.5	III.25	Bloomberg
									62.3	III.23	BREE
Алт	1632	-1.3%	9.8%	-0.2%	6.8%	21.8%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт нэмэгдэхээр байна.	1525	1554	III.25	Bloomberg
									1500	III.18	Roubini
									1474	III.23	BREE
Газрын тос (Брент)	27.2	1.5%	10.8%	-49.8%	-58.4%	-59.0%	COVID-19 вирусийн нөлөөгөөр эрэлт огцом буурах бол Сауди Араб, ОХУ үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр байгаа нь үнэ буурахад голлон нөлөөлж байна.	56	44	III.25	Bloomberg
									45	III.18	Roubini
									57	III.23	BREE